



**ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 21 өдөр

Дугаар СА/28

Улаанбаатар хот

**Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.3.7, 2.8, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын дүрмийн 5.5.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын Баримт нягтлан шалгах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дарга:	Захиргааны хэлтсийн дарга
Гишүүд:	Ерөнхий нягтлан бодогч
	Дотоод аудитор
	Хуулийн зөвлөх бөгөөд ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Архив, бичиг хэргийн мэргэжилтэн

2. Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагаанд хяналт тавин, зохион байгуулж ажиллахыг Комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын захирлын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/59 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Б.ХАЛИУН

